

“ЗҮҮН-ХОЙД АЗИЙН БҮС НУТГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ”

Д. БУМДАРЬ

МУИС. Улс төр судлалын тэнхимийн
дэд профессор, доктор

Түлхүүр үг: Зүүн-Хойд ази, аюулгүй байдлын асуудал, зүүн ази, бүс нутаг

Хураангуй: Зүүн-Хойд Азийн бүс нутагт Япон, Хойд Солонгос, Өмнөд Солонгос, Монгол, БНХАУ, ОХУ зэрэг улсууд багтдаг дэд бүс нутаг. Гэхдээ БНХАУ, Япон, Хоёр Солонгос бол газарзүйн хувьд ч, түүхэн болон соёлын хувьд ч энэ бүс нутгийн цөм гэж үздэг. ОХУ нь Алс Дорнод, Дорнод Сибирийн нутаг дэвсгэрээрээ энэ бүс нутагт багтдаг. Энэ бүс нутгийн улс орнуудын эрх ашгийг тэгш хангаж чадахуйц бүс нутгийн аюулгүй байдлын тогтолцоо хараахан бүрэлдэж тогтоогүй байна. Энд Америк болон түүний холбоотнуудын ашиг сонирхалд үйлчилсэн өмнөх үеийн хатуу тогтолцоо оршиж байгаа хэмээн судлаачид үздэг. Энэхүү судалгааны өгүүлэлдээ бүс нутгийн тухай ойлголт, Зүүн-Хойд Азийн бүс нутгийн улс орнуудын байр суурь, аюулгүй байдлын асуудлыг харьцуулан шинжлэхийг зорьсон болно.

Зүүн-Хойд Азийн бүс нутгийн онцлог байдлыг ойлгохын тулд дэлхийн бусад бүс нутгуудтай аюулгүйн байдлын хүрээнд хурцадмал байдал, сөргөлдөөн үүсэх магадлал, гарч болох үр дагавар зэрэг үзүүлэлтээр харьцуулж шинжлэх хэрэгтэй. Энэ зорилгоор Евро-Атлантын, Ойрхи дорнодын, Зүүн-Хойд Азийн бүс нутгуудыг¹ харьцуулж үзье. (Хүснэгт 1.)

Хүснэгт 1.

| | Евро-Атлант бүс нутаг | Ойрхи дорнод бүс нутаг | Зүүн-Хойд Ази бүс нутаг |
|--|--|--|---|
| Тухайн бүс нутагт багтдаг субъект (төр улс, олон улсын байгууллага, бусад субъект) | Баруун Европын том гүрнүүд (Франц, Герман, Их Британи), ОХУ, АНУ, Европын Холбоо, НАТО | Израиль, Иран, Египет, Саудын Араб, АНУ, ОХУ, төрийн бус субъект (Исламын радикал бүлэглэл-Аль Каида, Хамасс, Хезболла) | Хятад, Япон, Өмнөд Солонгос, Хойд Солонгос, Монгол, ОХУ, АНУ |
| Мөргөлдөөнийг үүсгэж болох эх үүсвэр | Пост социалист орон зайн төлөөх ОХУ болон Барууны орнуудын хоорондох сонирхолын зөрчил | Араб Израилын сөргөлдөөн, эсрэгцэл. Исламын радикал бүлэглэлийн үйл ажиллагаа | Тайваны асуудал, Иран, Солонгосын хойггын байдал. Хятад, Америкын хоорондын зөрчил. Хятад, Японы хоорондын зөрчил |
| Бүс нутгийн эдийн засгийн жин | Өндөр. Энэ бүс нутаг ҮНБ-ний хэмжээгээрээ дэлхийд тэргүүлдэг. | Өндөр. Нефть, байгалийн хий зэрэг нүүрст устөрөгчийн үйлдвэрлэлээр тэргүүлдэг. | Өндөр. Хойд америк болон Европын зэрэгцээ энэ бүс нутаг ҮНБ-рээ дэлхийд тэргүүлдэг. |
| Дэлхийн хэмжээний бодлого зохицуулалт нөлөөлөх боломж | Одоогоор өндөр, гэхдээ буурах хандлагатай. | Тийм боломжгүй. | Одоогоор бага, гэхдээ өсөх хандлагатай. |

Евро-Атлант бүс нутаг. Евро-Атлантыг дэлхийн ертөнцийн хамгийн гол бүс нутаг гэж өнөө үед шууд нотлох нь улс төрийн ёс зүйн хувьд төдийлөн зохимжтой биш ч гэсэн, бусад бүс нутгуудтай эн тэнцүү гэж үзэхэд эргэдхээр байгаа.

Дэлхийн үйл явдалд нөлөөлөхүйц томоохон зөрчил, мөргөлдөөн үүсгэх бүс нутгийн боломж бол уг бүс нутгийн олон улсын харилцаа-улс төрийн жинг илэрхийлдэг. Евро-Атлантын бүс нутгийн хурцадмал байдлын гол эх үүсвэр нь ОХУ болон барууны орнуудын хоорондох харилцаа юм. Уг бүс нутгийн бусад зөрчил, сөргөлдөөн нь бүс нутгийн чанартай. Гэхдээ Орос болон барууны орнуудын хоорондын харилцаа,

¹ Улс төрийн шинжлэх ухаанд хэрэглэж байгаа бүс нутаг хэмээх ойлголт бол газарзүйн гэхээсээ илүүтэй олон улсын харилцаа-улс төрийн агуулгатай нэршил. Энэ өгүүлэлд Зүүн-Хойд Ази, Евро-Атлант, Ойрхи Дорнодын бүс нутаг хэмээх ойлголтыг юуны өмнө олон улс харилцаа-улс төрийн утга, агуулгаар хэрэглэсэн болно.

ялангуяа Дорнод Европ, Өмнөд Кавказ зэрэгт нөлөөллөө тогтоох гэсэн тэдний өрсөлдөөн тэмцэл нь ямар ч байсан халуун дайны хямралд арай хүргэхгүй гэж үздэг.

Бүс нутгийн дэлхийн хэмжээний роль гүйцэтгэж чадах эсэхийн нэг шалгуур нь дэлхийн улс төр-эдийн засгийн үйл явдалд шийдвэрлэх нөлөө үзүүлэгч “төв” болж чадах эсэх асуудал юм. Өнөөгийн байдлаар Евро-Атлантын бүс нутаг тэргүүлэгч хэвээр байгаа нь маргаангүй. Глобал асуудал шийдвэрлэхэд голлох нөлөөтэй ОУВС, Дэлхийн банк, ОУХБ, ямар нэг хэмжээгээр НҮБ барууны орнуудын хяналтад байгаа. Хэдий тийм боловч Евро-Атлантын улс гүрнүүдийн нөлөө суларч Азийн орнуудын нөлөө, жин өсөн нэмэгдэж байгаа хандлага тогтвортой байгаа.

Ойрхи дорнод бүс нутаг. Энэ бүс нутаг бол дэлхийн нийтэд онцлог нөлөөтэй. Тэр нь дэлхийн эдийн засагт нийлүүлж байгаа нефть, байгалийн хий зэрэг энергийн эх үүсвэртэй нь холбоотой. Нефть, байгалийн хийн нөөц нь шавхагдсан нөхцөлд дээрхи онцлог нөлөөгөө алдах жишээтэй. Ирээдүйд хямд, илүү үр ашигтай энергийн эх үүсвэр бий болж нүүрст устөрөгчийн уламжлалт хэрэглээг эрс бууруулах тохиолдолд үүнтэй адил нөхцөл үүснэ. Энэ бүс нутагт дэлхийн нийтийн зүгээс анхаарах нэг учир шалтгаан бол радикал исламизмын аюул юм. Гэхдээ дан ганц исламизмын аюул нь уг бүс нутгийн дэлхийн бодлогод үзүүлж байгаа чухал ач холбогдолыг хадгалж чадахгүй. Нөгөө талаар Ойрхи дорнод бүс нутгийн улсууд Баруун Европ буюу НАТО-ийн гишүүд шиг хамтын, хамтарсан субъект биш учир глобал нөлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх боломжгүй.

Зүүн-Хойд Ази бүс нутаг. Зүүн-Хойд Азийн бүс нутаг² бол Ази-Номхон далайн том бүс нутгийн нэг хэсэг юм. Ийм учир ном хэвлэлд Зүүн Ази гэж бичих нь бий. Зүүн-Хойд Азийн бүс нутагт Япон, Хойд Солонгос, Өмнөд Солонгос, Монгол, БНХАУ, ОХУ зэрэг улсууд багтдаг дэд бүс нутаг. Гэхдээ БНХАУ, Япон, Хоёр Солонгос бол газарзүйн хувьд ч, түүхэн болон соёлын хувьд ч энэ бүс нутгийн цөм гэж үздэг. ОХУ нь Алс Дорнод, Дорнод Сибирийн нутаг дэвсгэрээрээ энэ бүс нутагт багтдаг.

Америк бол газарзүйн хувьд энэ бүс нутгийн гадна оршдог хэдий ч уг бүс нутгийн улс төр, эдийн засагт гүнзгий орсон байдаг төдийгүй цэргийн хүч нь байрладаг. Уг зүй нь Америк нь Евро-Атлантын бүс нутагт багтдагийг бодсон ч, Зүүн-Хойд Азийн гадна оршдогийг бодсон ч түүнийг энэ бүс нутагт багтаан ойлгоход хүндрэлтэй.

Хэрэг дээрээ Зүүн-Хойд Ази бол том Зүүн Азийн, бүр Ази-Номхон далайн бүс нутгийн геополитик, геоздийн засгийн төв-нь болдог бөгөөд эдгээр бүс нутгуудад шийдвэрлэх нөлөө үзүүлдэг. ЗХА нь Зүүн Өмнөд Азийн орнууд болон Энэтхэг улстай идэвхитэй харилцаа явуулж, улмаар бүс нутагтай стратегийн тэнцвэртэй байдлыг бий болгодог.

Энэ бүс нутгийн улс орнуудын эрх ашгийг тэгш хангаж чадахуйц бүс нутгийн аюулгүй байдлын тогтолцоо хараахан бүрэлдэж тогтоогүй байна. Энд Америк болон түүний холбоотнуудын ашиг сонирхолд үйлчилсэн өмнөх үеийн хатуу тогтолцоо оршиж байгаа юм.

Бүс нутгийн аюулгүй байдлын талаар Америкийн дэмжлэгтэйгээр шинэ хувилбарууд дэвшүүлж байгаа боловч тэр нь үеэ нэгэнт өнгөрөөж байгаа хоёр туйлт системийн үеийн аюулгүй байдлын талаарх АНУ-ын үзэл санааг илэрхийлж байна. Тухайн бүс нутгийн аюулгүй байдлыг хангах талаар өрсөлдөхүйц түвшний баримтлал дэвшигдэн гарч ирээгүй байна. Ийм нөхцөл байдлын хөрс суурин дээр энэхүү бүс нутагт урьд өмнө оршин байсан хийгээд шинэ төрлийн аюул занал улам бүр нэмэгдэх болов. Ойрхи дорнодын хямралт байдал нь үүнд бас нөлөөлж байгаа. Тухайлбал ЗХА-ийн бүс нутагт илэрхий цөмийн зэвсэгжих хандлага өсч байна.

Энэ бүс нутагт хоёр төрлийн томоохон эрсдэл байна. *Нэг дэх нь* – дайны аюул занал, ердийн болон цөмийн зэвсгийн тархалт гэх мэт уламжлалт эрсдэл. *Хоёр дахь нь* – терроризм, далайн дээрэм, хил дамнасан гэмт хэрэг, байгаль-экологийн гамшиг, техноген сүйрэл, хар тамхи, хууль бус дүрвэгсэд, эдийн засгийн болон энергийн аюул зэрэг уламжлалт бус шинэ эрсдэл.

Энэ хоёр эрсдэл нь байнга шинэчилэгдэн өөрчилөгдөж, шинэ үзэгдлүүдээр сэлбэгдэн нэмэгдэж, аюулгүй байдлын асуудал улам бүр олон талтай зөрчилдөөнтэй болж байна. Уламжлалт бус эрсдэл нь илүү хурдацтай өсөн нэмэгдэж байна.

Зүүн азийн бүс нутагт одоогоор аюулгүй байдалтай холбоотой гурван үзэл баримтлал оршин байна. Тухайлбал:

² Зүүн-Хойд Ази хэмээх нэршил нь бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор улс тус бүрийн үйлдвэрлэх хүч, дотоод нөөц бололцоог харгалзан 1980-аад онд Япон улсын зүгээс бүс нутгийг хөгжүүлэх боломжийг эрэлхийлсэн үеэс үүссэн хэмээн судлаачид үздэг. Энэхүү бодлогын зорилго нь “Япон- Солонгос улсын өндөр технологи, хөрөнгө оруулалт, Хятад- Хойд Солонгосын ажиллах хүч, Монгол- Орос улсын байгалийн баялаг” зэрэг улс тус бүрийн бодит боломжийг ашиглан бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн байдаг. Эхэн үедээ Японы эрэг хавийн улс орнуудын хамтын ажиллагаа хэмээх томъёололтой байсан бөгөөд хожим нь Монгол, Орос, Хятад улсын газарзүйн байршлыг харгалзан Зүүн-Хойд Азийн улс орнууд хэмээн нэрлэх болсон.

- *Нэг дах* нь АСЕАН-ны аюулгүй байдлын Форум. Сүүлийн жилүүдэд энэ Форум бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаар олон арван хурал зөвлөгөөн зохион байгуулж, бүс нутагт нээлттэй, тогтвортой байдал, харилцан итгэлцлийг гүнзгийрүүлэх талаар хэд хэдэн тунхаглал гаргасан. Гэхдээ энэ бүгд нь мэдэгдэхүйц үр дүнд хүрээгүй. Уг Форум нь хэрэг дээрээ шинжээчдийн зөвлөлдөх байгууллага бөгөөд ихэвчлэн зөвлөмж гаргадаг, харин тодорхой шийдвэр гаргаж хариушлага хүлээдэг байгууллага биш юм.
- *Хоёрдахь* нь, бүс нутгийн аюулгүй, тогтвортой байдлыг хангахад чиглэсэн Орос-Хятадын улс төрийн санаачлага юм. Энэхүү санаачлага нь Шанхай хамтын ажиллагааны байгууллагын (ШХАБ)³ хүрээнд, мөн хоёр орны хамтарсан мэдэгдэл, терроризмын эсрэг хамтын ажиллагаа зэрэгт тусгалаа олж хэрэгждэг. Бүс нутгийн бүх улс орны ашиг сонирхолыг хангахуйц Ази-Номхон далайн аюулгүй байдлын системийг бий болгох шаардлагатай байгаа талаар 2010 онд ОХУ-ын ерөнхийлөгч Д. Медведев, БНХАУ-ын ерөнхийлөгч Ху Цзиньтао нарийн улс төрийн мэдэгдэл нь дээрх санаачлагын нэг хэсэг юм.
- *Гуравдахь* нь хүйтэн дайны үед АНУ-аас Япон, Өмнөд Солонгос, Австрали зэрэг орнуудтай байгуулсан хоёр талын цэрэг, улс төрийн холбоо. Энэ бол бүс нутгийн улс орнуудын эрх ашигт бус, харин дан ганц Америк, түүний холбоотнуудын эрх ашигт нийцсэн загвар юм. Сүүлийн үед АНУ нь цэргийн салбарт хоёр талын хамтын ажиллагааны хэлбэрээс сүлжээ маягын хэлбэрт шилжих, улмаар Зүүн азийн бүс нутагт цэргийн хүчний төлөвлөлт, үйл ажиллагааны систем байгуулах санаа ажиглагдсаар байгаа. Энэ чиглэлд Америк – Тайландын “Алтан хорт могой”⁴ нэртэй цэргийн хамтарсан сургуулилалт нь хийгдсэн. Үүнд Филиппин, Япон, Сингапур, Өмнөд Солонгос улс оролцсон. Манай улс энэхүү сургуулилалтад нэгдэн орсон явдал нь сайтар тунгаан бодуштай үйлдэл биз.

Эхний хоёр үзэл баримтлал нь нээлттэй, ил тод бөгөөд цэрэг-улс төрийн ямарваа эвсэл холбоо бий болгоход чиглээгүй, тийм зорилго ч тавьдаггүй харин аюулгүй байдлын асуудлаар зөвшилцөл хэлэлцээний, эсвэл ШХАБ мэт иж бүрэн хамтын ажиллагааны хэлбэртэй юм. Гуравдахь (америк) үзэл баримтлал нь дээрхи хоёр загвараас үндсээрээ өөр бөгөөд Америк, зүүн азийн бүс нутаг дахь өөрийн холбоотнуудын ашиг сонирхолыг хамгаалахад чиглэсэн цэрэг-улс төрийн “хатуу түншлэл”-ийг бий болгохыг зорьдог. Түүгээр үл барам энэхүү “хатуу түншлэл”-ээ Хятад-Японы маргаантай Синкаку арал, Орос-Японы өмнөд Курилын арлуудыг хамран тэлэх эрмэлзэл ажиглагддаг.

Аюулгүй байдлын тухайд ийм нэг талыг барьсан хандлага оршин байгаагаас үүдэн уламжлалт болон шинэ төрлийн эрсдэл, аюул занал улам бүр өсөн нэмэгдсээр байгаа юм. Энэхүү байдал нь тус бус нутгийн уламжлалт аюулгүй байдлын асуудлыг дэвэргэж байна хэмээн үзэж болно. Тухайлбал, “Global Firepower” сэтгүүлийн 2016 оны дугаарт цэрэг армийн хүчээр нь дэлхийн 126 орныг эрэмбэлсэн байна. ОХУ хоёрдугаарт, БНХАУ гуравдугаарт, Өмнөд Солонгос улс долдугаарт, Япон улс есдүгээрт, Хойд Солонгос гучинзургаа дугаарт эрэмблэгдсэн.⁵ Энэ бүс нутаг цэрэг армийн хүчээр дэлхийд тэргүүлэх хэмжээнд хүрсэн байгааг харч болох юм. Цэрэг армийн хүч үгүй аваас гадаад харилцаанд хүч гарч чадахгүй хэмээх уламжлалт хандлага ч бас нөлөөлж байгаа юм.

Шинэ төрлийн эрсдэлийг авч үзвэл шилжин суурьшилт хэмээх түүх соёлын шинжтэй уламжлалт үзэгдэл сүүлийн жилүүдэд сөрөг криминаль өнгө аясыг ямар нэг хэмжээгээр тээх болов. Дэлхийн хүн амын 22%, олон янзын соёл, үндэстэн, угсаатан ястангууд Зүүн-Хойд Азид амьдарч байгаа нь нөлөөлөх хүчин зүйлсийн нэг юм. Бүс нутаг хоорондын ажил, хөдөлмөр эрхлэхтэй холбоотой хууль бус шилжин суурьшилт олон арав дахин нэмэгдэж, хүний наймаа болон дүрвэгсэд ихээхэн өсөж байна. Ийм үзэгдэл Зүүн өмнөд азийн орнуудад илүү ажиглагдаж байна.

Үүний зэрэгцээ эдийн засаг аюулгүй байдалд шууд болон шууд бусаар нөлөөлж байна. Амьдралын чанар, инфляци, ажилгүйдэл төсвийн алдагдал, алт валютын нөөцийн хэмжээ, далд эдийн засгийн эзлэх хувь, авилгын түвшин зэрэг үзүүлэлтүүд бүс нутгийн улс орон бүрт ихээхэн ялгаатай байна. Зүүн азид нэг хүнд ноогдох өндөр орлоготой Япон, Сингапур, Өмнөд Солонгос, Тайван, Бруней зэрэг улсууд, дунд зэргийн орлоготой Тайланд, Филиппин, Индонези, бага орлоготой Хятад, Канбож, Лаос, Мянмар, Вьетнам, Монгол, Хойд Солонгос зэрэг улсууд оршдог. Харин ҮНБ-нийг авч үзвэл Хятад улс бүс нутагт нэгдүгээр байранд, дэлхийд хоёрдугаарт, Япон улс дэлхийд гуравт орох жишээтэй.

Зүүн азийн бүс нутагт тулгарч байгаа экологийн сорилт нь хамрах цар хэмжээгээрээ улам бүр томорч, давтамж нь байнгын шинжтэй болж байна. 2010 оны Тайланд, Индонезийн цунами, 2011 оны Японы газар

³ SHANGHAI COOPERATION ORGANISATION- гишүүн орнууд БНХАУ, ОХУ, Казакстан, Киргиз, Таджикстан, Узбекстан гэсэн 6 улс байх ба Монгол улсын хувьд ажиглагч гишүүн улсын статустай.

⁴ <http://old.mgimo.ru/news/experts/document233966.phtml>

⁵ “Global Firepower-2016 Data and Charts”. jp.knoema.com/infographics/wxzygqd/global-firepower-2016-data-and-charts.

хөдлөлт нь техногений томоохон сүйрэл авчирсан. Өөрөөр хэлбэл экологийн асуудал нь энэ бүс нутагт цэвэр экологийн хүрээнээс хальж илүү гүнзгий үр дагавартай болж байна.

Мөн энэ бүс нутгийн аюулгүй байдалд эрсдэл дагуулж буй кибер хамгааллын асуудал, дэлхийн хамтын эзэмшлийн хүрээнд үүсэх эрсдэл (сансар огторгуй, далайн гэрээ зэрэгт харилцан адилгүй хүчин чадалтай оролцох) зэрэг шинэ эрсдэл, сорилтууд үүсэж байгаа.

Геополитикийн нөхцөл байдал нь Зүүн азийн аюулгүй байдалд бас нөлөөлдөг. Энд Хятад-Америкийн харилцаа голлох нөлөөтэй бөгөөд зөвхөн Ази-Номхон далайн бүс нутгаар хязгаарлагддаггүй глобал шинжтэй юм. Энэ хоёр орон нэг талаас “харилцан хамаарал” нь нэмэгдэж, нөгөө талаас “үл ойлголцох асуудал” нь хүрээгээ тэлэх хандлагатай байна. Тайвань, Түвдийн асуудал, хүний эрхийн асуудал, юань-долларын ханш зэрэг нь хоёр орны харилцаанд зөрчил үүсгэдэг. Үүн дээр Ойрхи дорнод, Хойд Солонгос, НҮБ-ийн шинэчлэл, НАТО-гийн өргөжин тэлэлт мэт геополитикийн асуудлууд нэрмээс болдог. Үүний зэрэгцээ хоёр орны санхүүгийн эдийн засгийн хүрээний харилцан хамаарал улам бүр хүчтэй болж байгаа. Хятад улсад Америкийн зах зээл хэрэгтэй байгаа, Америкийн компаниуд Хятадын зах зээлийг ихэд сонирхдог. Америкт хятадын талын лобби ч байгаа, Хятадад америкийн талын лобби ч байгаа. Энэ нөхцөл байдал цаашидаа хэрхэх нь тодорхойгүй байна.

Япон-Хятадын уламжлалт зөрчилт түүхэн асуудлууд бүрмөсөн шийдэгдээгүй хэвээр байгаа бөгөөд хятад-америкийн харилцааг бодвол илүү бүс нутгийн шинжтэй юм. Эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагаа тогтвортой өрнөж байгаа боловч Япон дахь Америкийн цэргийн бааз болон Япон улсын цэрэг зэвсэгжих хандлагад Хятад улс санаа зовниж байдаг.

Хоёр Солонгосын харилцааны асуудал нь бүс нутгийн түвшингээс хальж глобал шинжтэй болсон. Хойд Солонгосын цөмийн зэвсгийн асуудлыг зохицуулах 6 орны (Америк, ОХУ, Хятад, Япон, Омнөд Солонгос, Хойд Солонгос) хэлэлцээр 2010 оноос мухардалд ороод байгаа. Энэ асуудлаар ахиц дэвшилд хүрэхийн тулд шинэ арга хандлага хэрэгтэй байна.

Орос-Хятадын стратегийн түншлэл хоёр орны хувьд онцгой ач холбогдолтой байгаа. ОХУ Нэгдсэн Үндэсний Байгууллагын Аюулгүй Зөвлөлийн байнгын гишүүн, олон улсын бусад томоохон байгууллагын гишүүн, 4300 км урт хил дагуу тогтвортой байдлыг хангагч улсын хувьд БНХАУ-д нэн чухал ач холбогдолтой. Нөгөө талаас ОХУ нь энергийн эх үүсвэр (газрын тос, байгалийн хий)-н нэн чухал нөөц юм. Цаашдаа ч Оросын энергийн эх үүсвэрийн ач холбогдол нь Хятад улсын хувьд өсөн нэмэгдэх хандлагатай байна. ОХУ-ын Сибирь, Алс дорнод Хятадын хөрөнгө оруулагчид болон ажиллах хүчний хувьд ихээхэн сонирхолтой. Хятад улс өөрийн Зүүн хойд мужуудаа хөгжүүлэх, Сибирь-Алс дорнодтой холбох, бодлого барьж байна.

В.В. Путин “Өөрчлөгдөж байгаа дэлхий ертөнц ба Орос орон (2012)” өгүүлэлдээ Орос-Хятадын харилцааны асуудлаар чухал үзэл санааг дэвшүүлсэн байдаг. Үүнд:

- “Хятадын эдийн засгийн өсөлт бол аюул занал биш, харин үр дүнтэй, ажил хэрэгч хамтын ажиллагааны асар их боломжийг агуулсан үзэгдэл юм. Манай эдийн засгийн далбаат онгоцууд “хятадын энэхүү салхи”-ийг барьж авч ашиглаж чадах ёстой. Бид хамтын ажиллагаагаа дээд зэргийн идэвхитэй өрнүүлж, хоёр талын технологи, үйлдвэрлэлийн боломжийг дайчилж, Сибирь-Алс дорнодын шинэ эдийн засгийг цогцлоох ёстой.”
- Хятад улсын олон улсын тавцан дахь үйл ажиллагаанаас жанжлах ямар нэгэн санаа зорилго илрэхгүй байгаа. Хятад улсын санал, санаачлага дэлхийн нийтэд улам бүр жинтэй болж байгаад бид талархах ёстой, учир нь улс орнуудын эрх тэгш харилцаанд суурилсан дэлхийн нийтийн шинэ дэг журам тогтож байгаа талаарх манай дүгнэлт, үзэл бодлыг Хятад улс хуваалцдаг.
- Манай хоёр улсын хувьд хилийн асуудлыг оролцуулаад бүх том асуудлууд нэг мөр шийдэгдсэн. Хоёр талын харилцааны асуудлууд хууль эрх зүйн баримт бичгээр зохицуулагдсан. Хоёр улсын удирдлагын түвшинд түүхэнд урьд өмнө байгаагүй өндөр түвшний харилцан итгэлцэл бий болоод байна”⁶ гэж цохон тэмдэглэсэн байна.

Сибирь, Алс дорнодыг хөгжүүлэхэд ОХУ Япон улстай хамтран ажиллах эрэлт ихээхэн байна. Энэ нь нэг талаас ОХУ энергийн эх үүсвэрээ Япон улсад экспортлох, нөгөө талаас Японы хөрөнгө оруулалтыг татах, хамтарсан томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх хоёр талын сонирхолоор илэрч байна. ОХУ-ын ерөнхийлөгч В.В. Путин 2016 оны 12 дугаар сард Япон улсад хийсэн албан ёсны айлчлал, уг айлчлалын үеэр болсон Путин, Абэ нарын дээд хэмжээний уулзалт, хэлэлцээр нь хоёрын харилцааны хөгжилд чухал ач холбогдолтой болсон. Курилын арлууд, энх тайвны гэрээ зэрэг асуудлаар тодорхой шийдэлд хүрээгүй ч, эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд үлэмж ахиц дэвшил гарсан. Айлчлалын үеэр харилцан ашигтай олон арван томоохон гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурсан явдал нь харилцан ойлголцол, эдийн

⁶ В.В.Путин в статье “Россия и меняющийся мир” (27.02.2012 г.)/Московские новости, 27 февраля 2012.

засгийн харилцааны хөгжилд шинэ далайц, эрч хүч өгч байна.

Зүүн-Хойд Азийн бүс нутгийн орны хувьд манай улс бүс нутгийнхаа улс орнуудтай харилцах харилцаагаа хөгжүүлэх өргөн боломж бий. Манай орны хувьд бүс нутгийн улс орнуудтай тогтоосон харилцаа нь цэрэг, улс төрийн гэхээсээ илүүтэй эдийн засгийн гүнзгий учир холбогдолтой. Эдийн засгийн өсөлтийг хангах, ард түмний амьжиргааны түвшинг дээшлүүлэх тулгамдсан том асуудлыг бүс нутгийн улс орнуудтай хамтын ажиллагаагаа эрчимтэй хөгжүүлэх замаар шийдвэрлэх боломжтой гэдэг нь сүүлийн 30 шахам жилийн бодит амьдралаар нотлогдож байна. Энд манай орны зүгээс гаргах санаачлага нэн чухал үүрэгтэй гэдэг нь илэрхий юм. Манай зүгээс бүс нутгийн улс орнуудтай хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлж ирсэн боловч энэ нь өнөөгийн эрэлт шаардлагыг төдийлөн хангахгүй байгаа. Монгол улсын сүүлийн жилүүдэд баримталж ирсэн гадаад бодлого нь эдийн засгаа хөгжүүлэх эн тэргүүний зорилттойгоо тэр бүр уялдаагүй байсан нь нууц биш.

Манай улс төвийг сахих үзэл баримтлалаасаа татгалзсан явдал нь Зүүн-Хойд Азийн бүс нутгийнхаа улс орнуудтай хамтын ажиллагаагаа шинэ түвшинд хөгжүүлэх үүд хаалга нээгдэж байна. Тухайлбал, Монгол-Орос, Монгол-Хятад, Монгол-Япон, Монгол-Солонгос зэрэг хоёр талын хамтын ажиллагаа, мөн Евро-Азийн хамтын ажиллагааны байгууллага, Шанхайн хамтын ажиллагааны байгууллага, Зүүн-Хойд Азийн улсуудын нийгэмлэг болон бусад эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагуудтай хамтарч ажиллах боломж нээгдэж байна.

Abstract: In the 21 century safety and security is becoming increasingly difficult for states to determine a way to prevent potential problems and crisis. Globalization is one of the main causes. According to international relations theory, realists believe that globalization is the fundamental source of conflict, but liberals believe that it will create political convergence with the states government in the future. Furthermore, the impact of globalization on international communication system and a regional security has a positive and negative effects. This causes security increase and re-design preventive way for states government to be improved. It can be said that international relations and the regional balance of power problems can face danger and lose stability due to globalization. Crisis management and its strategy must be able to anticipate and predict crisis.

НОМ ЗҮЙ:

1. Монгол улс Аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2011.
2. Монгол улсын гадаад бодлогын хөх ном. УБ., 2016
3. モーゲンソー、原彬久 監訳『国際政治—権力と平和—』（岩波書店、2013年）
4. ヘドリー・ブル、臼杵英一訳『国際社会論—アナーキカル・ソサイエティ』（岩波書店、2000年）
5. 奥山真司『地政学』（五月書房、2004年）
6. 三輪俊和「戦後70年と東アジアの平和構造」、北九州医療・福祉総合研究所年報第22号
7. フランシス・フクヤマ、渡部昇一 訳『歴史の終わり』（三笠書房、2005年）
8. 細谷雄一『国際秩序』（中公新書、2012年）
9. Под ред. А.Д. Восресенского “Большая Восточная Азия”: мировая политика и региональные трансформации. МГИМ (У) МИД РФ, 2010.
10. В.В.Путин в статье “Россия и меняющийся мир” (27.02.2012 г.)/Московские новости, 27 февраля 2012
11. Arnold Wolfers, “National Security’ as an Ambiguous Symbol”, Political Science Quarterly, Vol.67, No.4, December 1952
12. David A. Baldwin, “The Concept of Security” Review of International Studies, 1997
13. J. Rawls. The law of People with: “The Idea of Public Reason Revisited”, (Harvard University Press 2001)
14. “Global Firepower-2016 Data and Charts”, jp.knoema.com/infographics/wxyzqgd/global-firepower-2016-data-and-charts